



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж 11,
Утас: 264216, Факс: 264460

ДАРГА НАРТ

2012.11.01 № 805
танай _____-ны № _____-т

Сургалтанд оролцуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг тус тус баталж, 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдөхөөр тогтоосон болно.

Эдгээр журмуудыг дараа оны эхнээс хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд "Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ боловсруулах, байгуулах, дүгнэх аргачлал" сэдэвт 1 өдрийн сургалтыг Төрийн албаны зөвлөлийн Сургалтын танхимд 2012 оны 11 дүгээр сарын 7-9 ны өдрүүдэд зохион байгуулах тул, сургалтад оролцох төрийн албан хаагчийн овог нэр, холбоо барих утасны дугаарыг тус зөвлөлийн Ажлын албаны 265045 болон 99069073 дугаарын утас руу холбогдон 11 дүгээр сарын 06-ны өдрийн дотор шинжээч Ц.Зоригтбаатарт өгнө үү.

Өөрийн байгууллагын төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний асуудал хариуцсан албан хаагчийг хуваарийн дагуу оролцуулж дараа нь оролцсон төрийн албан хаагч байгууллагадаа болон харъяа байгууллагуудаа энэхүү сургалтыг үргэлжлүүлэн явуулахаар төлөвлөж зохион байгуулах нь зүйтэй. Сургалтын хөтөлбөр, хуваарийг хавсаргав.

Жич: Орон нутгаас сургалтанд оролцох төрийн албан хаагчдын нэг өдрийн томилолтын зардлыг Төрийн албаны зөвлөлөөс олгох бөгөөд ирж очих унааны зардлыг холбогдох байгууллага хариуцана.



Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

БАТЛАВ



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

“Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн
гэрээ боловсруулах, байгуулах, дүгнэх”
сэдэвт арга зүйн сургалтын хөтөлбөр

2012 оны 11 дүгээр сарын 7-9

Хугацаа	Сэдэв
9:00 - 9:10	Нээлт, Төрийн албаны зөвлөлийн дарга Д. Зүмбэрэллхам
9:10 – 10:30	Гүйцэтгэлийн удирдлага, үнэлгээ, шалгуур үзүүлэлт
10:30 – 10:45	Цайны завсарлага
10:45 – 12:30	Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх нь
12:30 – 13:30	Өдрийн хоол
13:30-15.00	Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх нь
15:00-15.20	Цайны завсарлага
15:20 – 16:30	Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх нь
16.30-16.50	Хаалт, сургалтын дүгнэлт

Сургалтын ерөнхий хуваарь

№	Байгууллага	Хугацаа
1	Яам, төр, засгийн удирдах дээд байгууллагын Ажлын алба болон Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын Ажлын алба	2012.11.7
2	Засгийн газрын агентлаг	2012.11.8
3	21 аймаг, нийслэл, 9 дүүрэг	2012.11.9

**“Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ боловсруулах,
байгуулах, дүгнэх аргачлал ” сэдэвт сургалтын хуваарь**

2012 оны 11 дүгээр сарын 7ны өдөр

Хамрагдах байгууллага : Яам, төр, засгийн удирдах дээд байгууллагын Ажлын алба
болон Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын Ажлын алба

№	Яам, байгууллагын нэр
1	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
2	Барилга, хот байгуулалтын яам
3	Батлан хамгаалах яам
4	Боловсрол, шинжлэх ухааны яам
5	Гадаад харилцааны яам
6	Зам тээврийн яам
7	Сангийн яам
8	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
9	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
10	Уул уурхайн яам
11	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
12	Хууль зүйн яам
13	Хөдөлмөрийн яам
14	Эдийн засгийн хөгжлийн яам
15	Эрүүл мэндийн яам
16	Эрчим хүчний яам
17	УИХ-ын Тамгын газар
18	Ерөнхийлөгчийн Тамгын газар
19	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
20	Улсын дээд шүүхийн Тамгын газар
21	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба
22	Үндсэн хуулийн цэцийн Ажлын алба
23	Сонгуулийн ерөнхий хороо
24	Улсын Ерөнхий прокурорын газар
25	Авилгатай тэмцэх газар
26	Санхүүгийн зохицуулах хороо
27	Үндэсний аудитын газар
28	Үндэсний статистикийн хороо
29	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс
30	Хүний эрхийн үндэсний комисс



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 35 дугаар зүйлийн 35.1.5 дэх хэсгийг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг 2 дугаар хавсралтаар, "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар болон төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлт)-г үнэлэх журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 48 дугаар тогтоол, "Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй, Ерөнхий менежер менежер (нэгжийн дарга)-тэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар болон тэдгээрийн биелэлтийг дүгнэх журмыг шинэчлэн батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 187 дугаар тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

ТАЗ тогтоол 2012
120416

